

8-р ангийн физикийн хичээлийн анги дэвших шалгалтын материал


А хувилбар

1. Доорх тэмдэглэгээнүүдээс даралтыг нэгжтэй нь зөв сонгосон хариулт аль нь вэ? 1 оноо

- A. Ньютон, Н/м²
- C. Паскаль, кг

- B. Паскаль, Н/м²
- D. Ньютон, кг

2. Янз бүрийн хэлбэртэй савнуудыг зурагт үзүүлжээ. Тэдгээрт h түвшинтэй шингэн байсан бол аль савны ёроол дахь шингэний даралт их байх вэ? 1 оноо




- A. I савны
- B. II савны
- C. III савны
- D. IV савны
- E. Бүх саванд ижилхэн

3. Агаарын даралт нь 0 хэмийн температурт 48 өргөрөгт далайн төвшин дээр хэмжсэн даралтын хэмжээг гэдэг. 1 оноо

- A. Агаарын даралт
- C. Салхи

- B. Хэвийн даралт
- D. Шингэний даралт

4. Зурагт эргэвчээр ачааг жигд өргөх хүчийг олно уу? 1 оноо



- A. 30 Н
- B. 3кН
- C. 10 кН
- D. 1 кН

5. Пүршинд 200 г масстай ачаа зүүхэд 8 мм - ээр сунажээ. Тэгвэл 1.2 кг масстай ачаа зүүвэл пүршний урт хэмжээгээр сунах вэ? 1 оноо

A. 48 мм

B. 488 мм

C. 4.8 мм

D. 48 см

6. Морьтой хүн тал дээр 3 м/с хурдтай 2 цаг явжээ.Түүний явсан замыг олно уу? 1 оноо


A. 6 м

B. 21600 м

C. 6 км

D. 21600 км

7. Дараах графикийн аль хугацааны завсарт бие хурдсах хөдөлгөөн хийсэн бэ? 1 оноо



- A. 0- t_2
- B. t_1 - t_2

C.0- t_1
D. t_1-t_3

8. Дараах ухагдахуун үгнүүдээс аль нь энергийн нэгж вэ? 1 оноо

A. Энерги В. Жоуль С. Ньютон D. Ампер

9. Цахилгаан гүйдлийн ажил буюу энергийг аль томъёогоор тооцоолдог вэ? 1 оноо

A. $E=mgh$ В. $E=kx^2/2$ С. $E=IUt$ D. $E=FS$

10. Сурагч хулдаасан шалыг гутлынхаа улаар үрж байснаа хуруугаа өөр хүүхдэд хүргэхэд оч үүсэж час час хийх дуу гардаг. Энэ нь ямар үзэгдэлтэй холбоотой вэ? 1 оноо

A. Гэрлийн В. Соронзон С. Цахилгаанжих D. Дулааны

11. Энергийн нэг хэлбэрээс нөгөө хэлбэрт хувирах үед энергийн хэмжээ 1 оноо

A. Ихсэнэ В. Багасна С. Хадгалагдана D. Устаж алга болно

12. Биеийг хэр зэрэг халуун хүйтэн байгааг илэрхийлдэг хэмжигдэхүүнийг физикт гэнэ. 1 оноо

A. Градус В. Температур С. Термометр D. Дулаан

13. Парис хотын Эйфелийн цамхаг 9000 т масстай ба 450 м² талбай дээр тулж байдаг байна. Түүний газарт учруулах даралтыг олоорой. /2 оноо/

A. 200 кПа В. 400 кПа С. 100 кПа D. 10 кПа


14. 1000кг/м³ нягттай шингэн 40см өндөр саванд дүүрэн байв. Энэ шингэний ёроолдоо учруулах даралтыг ол. 2оноо

A. 400 Па В. 4 Па С. 4000 Па D.40000 Па

15. Уулын бэлд агаарын даралт 754 мм.м.у.б, уулын оройд 694 мм.м.у.б байв. Уулын өндөр ямар байхыг олно уу? / Агаарын даралт 12 м өндөрт 1 мм м.у.б- аар багасдаг. /2 оноо/

A.72 м В. 720 м С.62 м D. 620 м

16. Зурагт үзүүлсэн хүчнүүдийн нийлбэр хүчийг олоорой 2 оноо




- A. 130 Н B. 50 Н C. 70 Н D. 60 Н

17. 10 кН/м хаттай пүршийг 2 мм сунгахад үүсэх уян харимхайн хүчийг олно уу? 2 оноо

- A. 200 Н B. 0.2 Н C. 20 Н D. 2 Н

18. Зурагт үзүүлсэн савааны урт 4м бол тэнцвэр байлгахын тулд олсны үйлчлэх хүчнүүд ямар байх шаардлагатай вэ? 2 оноо



- A. 15 Н, 25 Н
 B. 10 Н, 30 Н
 C. 20 Н, 20 Н
 D. 5 Н, 35 Н
 E. 0 Н, 40 Н

19. Механикийн алтан дүрмээр хүч хожвол зам алддаг. Энэ дүрэм аль системд биелэх вэ? 2 оноо

- A. Үл хөдлөх эргэвч
 B. Хөдлөх эргэвч
 C. Хоёуланд нь биелэнэ
 D. Хоёуланд нь биелэхгүй
 E. Бүх хариулт буруу

20. Морь тэргийг уул өөд чирч байна. Уулын налуугийн урт 60 м, өндөр 12 м, морины чангаах хүч 720 Н бол тэрэгний масс олоорой. 2 оноо

- A. 720 кг B. 360 кг C. 120 кг D. 100 кг


21. Дараах хурдуудын аль нь тэнцүү хурд вэ ? 2 оноо

- A. 12 м/с = 12 км/ц B. 12 м/с = 4,32 км/ц C. 12 м/с = 432 км/мин D. 12 м/с = 43,2 км/ц

22. Моторт завь 50 км зайг урсгал дагуу 2 цаг, урсгал сөрж 3 цагт туулсан бол завины дундаж хурд ямар байх вэ? 2 оноо

- A. 68 км/ц B. 58 км/ц C. 80 км/ц D. 50 км/ц


23. Эгц дээш шидсэн бие эргэж газарт унав. Хөдөлгөөнд тохирох хурд хугацааны хамаарал аль нь вэ? 2 оноо



32. Хэрэв гүйдэлтэй ороомгийг -вэл соронзон орон нэмэгдэнэ. 2 оноо


- | | | | |
|---|---|--|---|
| A. ороомог дахь дамжуулагч утасны тоог багасгавал | B. ороомог дахь гүйдлийн хүчийг ихэсгэхэд | C. гүйдэлтэй ороомгийн радиусыг нэмбэл | D. Ороомог дахь Дамжуулагчийн хөндлөн огтлолыг багасгахад |
|---|---|--|---|

33. Авто засварын газар шингэнт төхөөрөмж ашиглаж 1800 кг масстай машиныг өргөжээ. Жижиг бүлүүрийн талбай 25 см² том бүлүүрийн талбай 225 см² бол машиныг өргөхийн тулд жижиг бүлүүр дээр ямар хүчээр дарах вэ? / 2оноо/



- A. 1000Н
- B. 2000Н
- C. 3000Н
- D. 6000Н
- E. 9000Н

34. Биеийн хөдөлгөөний хурдатгал хугацааны хамаарлыг ашиглан биеийн хурдыг олно уу?



- A. 4 м/с
- B. 2 м/с
- C. 0
- D. 8 м/с
- E. 6 м/с

35. 500 м өндрөөс бууж байгаа шүхэрчин 80 кг масстай бол түүний кинетик энерги 100 м өндөрт ямар байх вэ? 1 оноо

- | | | | | |
|-----------|-----------|-----------|-----------|----------|
| A. 100 кЖ | B. 320 кЖ | C. 640 кЖ | D. 400 кЖ | E. 80 кЖ |
|-----------|-----------|-----------|-----------|----------|

36. Хий, шингэн, хатуу биеийн бөөмсийн харилцан үйлчлэлээр халсан хэсгээс бага халсан хэсэг руу энерги зөөгдөхийг . . . гэдэг. 1 оноо

- | | | | |
|------------|---------------------|-----------|---------------|
| A. Конвекц | B. Дулаан дамжуулал | C. Цацрал | D. Конденсаци |
|------------|---------------------|-----------|---------------|

37. Өрөө 200 С байхад тайван байгаа хүн цагт 419 кЖ энерги алддаг. Арьсны дамжууллаар 15% - ийг алдана. Мэдээллийг ашиглаад тайван байгаа хүнээр тооцоолол хийгээрэй. 1 оноо

- | | | | |
|---------|---------|---------|---------|
| A. 1258 | B. 1257 | C. 1256 | D. 1259 |
|---------|---------|---------|---------|

2-р хэсэг

2.1 Хоорондоо 90° өнцөг үүсгэсэн 4 Н ба 3 Н хүчнүүд өгөгджээ.

A. Хүчнүүдийг зургаар дүрсэлж үзүүлнэ үү? 2 оноо

.....
B. Тэдгээрийн нийлбэр хүчийг олоорой 2 оноо

2.2 $R_1=2$ Ом $R_2=3$ Ом эсэргүүцэлүүдтэй биеүдийг цуваа холбожээ. Түүний хүчдэл нь 40В бол

a. Схемийн зурна уу..... 1 оноо

b. нийт эсэргүүцэл нь..... (...)нэгж 2 оноо

c. гүйдлийн хүч нь (...) нэгж 1 оноо

2.3 Өргөгч цамхагаар хэвтээ байрласан 5 м урттай, 7800 кг/м³ нягттай, 10 см² хөндлөн огтлолтой савааг 1.2 м өндөрт өргөх ажлыг олно уу?

A. Савааны эзэлхүүн хэд байсан бэ? 1 оноо

.....
B. Савааны масс хэд байсан бэ? 1 оноо

.....
C. Ямар ажил хийсэн бэ? 1 оноо

.....
D. Хийгдсэн ажил ямар энергитэй тэнцүү вэ? 1 оноо

.....

8-р ангийн физикийн хичээлийн анги дэвших шалгалтын материал

В хувилбар

1. Хатуу биеийн гадаргуунд үзүүлэх даралт аль нь вэ? 1 оноо

A. $P=F/S$

B. $P=F*S$

C. $P=pgh$

D. $P=p_0+pgh$

2. Шингэн биеийн хэлбэр хэмжээ нь дараах шинжтэй байна 1 оноо

A. Оршин буй орон зайгаа дүүргэдэг

B. Агуулж буй савны хэлбэрээ дагадаг

C. Өөрийн гэсэн хэлбэр дүрсээ хадгалдаг

D. Ямар ч байж болох юм

3. Хийн буугаар чанасан өндөгийг буудахад нүх гардаг. Харин түүхий өндөгийг буудахад зад үсэрдэгийн учрыг тайлбарлана уу? 1 оноо

A. Шингэн болон хатуу биеийн даралт ялгаатай учраас

B. Хий шингэний даралт ялгаагүй учраас

C. Чанасан өндөг хатуу, чанаагүй өндөг зөөлөн учраас

D. Аль нь ч биш

4. Биед харилцан перпендикуляр 3 Н ба 4 Н хүч үйлчилжээ. Тэнцүү үйлчлэгч хүчийг олно уу 1 оноо

A. 5 Н

B. 7 Н

C. 1 Н

D. 12 Н

5. Дараах зүйлсээс алийг нь хүчийг хожих (замыг алдах) зориулалтаар ашиглаж болох вэ? 1 оноо
а б в г д



6. Дараах хурдуудын аль нь тэнцүү хурд вэ? 1 оноо

A. $36 \text{ км/ц} = 36 \text{ м/с}$


B. $36 \text{ км/ц} = 3.6 \text{ м/с}$

C. $36 \text{ км/ц} = 10 \text{ м/с}$

D. $36 \text{ км/ц} = 10 \text{ км/ц}$

7. Зурагт гурван төрлийн хөдөлгөөнийг үзүүлжээ. Босоо нарийн шугам бүрийн хооронд 1 секунд бүрд туулсан замын хэмжээг бичсэн байна. Энэхүү гурван хөдөлгөөнийг зөв оноож нэрлэсэн хариулт аль нь вэ? 1 оноо


- A. 1- хурдсах хөдөлгөөн, 2 – жигд хөдөлгөөн, 3–удаашрах хөдөлгөөн
- B. 1- хурдсах хөдөлгөөн, 2-удаашрах хөдөлгөөн, 3 – жигд хөдөлгөөн
- C. 1-удаашрах хөдөлгөөн, 2–жигд хөдөлгөөн, 3 – хурдсах хөдөлгөөн
- D. 1- удаашрах хөдөлгөөн, 2 – хурдсах хөдөлгөөн, 3 – жигд хөдөлгөөн



8. Доорх нэгжүүдээс аль нь энергийн нэгж вэ? 1 оноо

- A. Ватт
- B. Жоуль
- C. Вольт
- D. Кулон

9. Цахилгаан хэлхээн дэх тэмдэглэгээг нэрлэнэ үү 1 оноо



- A. хонх, чийдэн, эсэргүүцэл, түлхүүр
- B. хонх, түлхүүр, эсэргүүцэл, конденсатор
- C. хонх, гүйдлийн үүсгүүр, эсэргүүцэл, конденсатор
- D. Хонх, чийдэн, түлхүүр, гүйдлийн үүсгүүр

10. Гүйдэлтэй дамжуулагч соронз хоёр харилцан үйлчилж байхад хүч утсанд чиглэнэ 1 оноо

- A. Гүйдлийн дагуу
- B. Гүйдлийн эсрэг
- C. Хөндлөн
- D. Аль нь ч биш

11. Цахилгаан энерги дулааны энергид хувирахад чийдэнгийн улайсах нарийхан утас ямар үүрэг гүйцэтгэх вэ? 1 оноо

- A. Энерги тээгч
- B. Энерги хувиргагч
- C. Энергийн нэг хэлбэр
- D. Гэрлийн энерги

12. Хоёр төрлийн чийдэнгийн энерги хувиргалтыг зурагт үзүүлэв. Аль чийдэнг худалдаж авах нь зүйтэй талаар зөвлөгөө өгнө үү? 1 оноо

- A. 1- р чийдэн
- B. 2- р чийдэн
- C. 1 Болон 2
- E. Аль нь ч



13. Парис хотын Эйфелийн цамхаг 9000тн масстай ба нийт 450м2талбай дээр тулж байдаг. Газарт учруулах даралтыг тодорхойл. 2 оноо

- A. 4050 кПа В. 200 кПа С. 20 кПа D. 405 Па


14. Саванд 8м өндөртэй үл мэдэгдэх шингэн хийхэд савны ёроолд 928кПа даралт учирч байсан тул үл мэдэгдэх шингэний нягтыг тодорхойлно уу? 2 оноо

- A. 12700 кг/м³ В. 11700 кг/м³ С. 12600 кг/м³ D. 11600 кг/м³

15. Барометр уулын энгэрт 680 мм м.у.б, оройд 622 мм м.у.б зааж байв. Уулын өндрийг ол. 2 оноо

- A. 670 м В. 696 м С. 698 м D. 697 м

16. Үл сунах утсыг таазанд бэхлэн ачаа бүхий эргэвчээр зурагт үзүүлсэн байдлаар хагас ороон дээш 100 Н хүчээр татаж байгаа бол ачаа хэдэн Ньютон жингээр доош татах вэ? 2 оноо



- A. 100 Н
B. 50 Н
C. 200 Н
D. 0,1 Н

17. 10 кН/м хаттай пүршийг 2 мм сунгахад үүсэх уян харимхайн хүчийг олно уу? 2 оноо

- A. 2000 Н В. 0,2 Н С. 20 Н D. 2 Н

18. Эргүүлгийн голын диаметр 20 см ба бариулын эргэх дугуйн радиус 50 см болно. Тэгвэл 120 Н жинтэй хувинтай усыг өргөхөд ямар хүч шаардах вэ? 2 оноо

- A. 10 Н В. 24 Н С. 36 Н D. 48 Н

19. Хөшүүргийн ($l_1=20$ см, $l_2=50$ см) урт мөрөнд зүүсэн ачааны массыг олно уу? $M_2=400$ г 2 оноо

- A. 100 г В. 160 г С. 400 г D. 320 г

20. Сурагч 40 см урттай хөшүүргийг тэнцвэрт оруулсан байна. Тэрээр хөшүүргийн баруун үзүүрт 50 г, зүүн үзүүрт 150 г ачаа зүүжээ. Тулах цэгийг хаана байрлуулсан бэ? 2 оноо

- A. Баруун үзүүрээс 10 см зайд В. Баруун үзүүрээс 20 см зайд

С. Баруун үзүүрээс 30 см зайд

D. Баруун үзүүрээс 40 см зайд

21. Унадаг дугуйтай хүн 5 цаг 30 минутанд 99 км зам явна. Тэрээр ямар хурдтай явсан бэ? 2 оноо

A. 5 м/с

B. 50 м/с

C. 0,5 м/с

D. 4,5 км/ц

22. Дараах графикийн аль хугацааны завсарт бие зогссон бэ? 2 оноо



A. 0- t₁


B. t₁ - t₂

C. t₁ - t₃

D. t₀ - t₂

23, 24, 25 дугаар даалгаврын өгөгдөл

Зурагт өгөгдсөн графикийг ашиглан дараах даалгавруудыг гүйцэтгээрэй



23. Дээрх графикаар ямар хэмжигдэхүүнүүдийн хамаарлыг илэрхийлж байна вэ? 2 оноо

A. Зам, хугацаа

B. Зам хурд

C. Хурд, хугацаа

D. Хурд хурдатгал

24. Графикийн аль хэсэгт бие тогтмол хурдтай хөдөлсөн бэ? 2 оноо

A. BC хэсэгт

B. CD хэсэгт

C. AB хэсэгт

D. DE хэсэгт

25. Графикийн CD хэсэгт биеийн хурдатгал ямар байна вэ? 2 оноо

A. 8 м/с²

B. 4 м/с²

C. 2 м/с²

D. 0.5 м/с²

26. Уул өөд гүйж яваа хүн ямар энергитэй байх вэ? 2 оноо

A. Потенциал энерги

B. Кинетик энерги

C. Кинетик ба потенциал

D. Энерги алга болно

27. 60 кг масстай ачааг шалнаас өргөж ширээн дээр тавив. Ширээний өндөр 2м бол потенциал энергийн өөрчлөлтийг олно уу? $g=10$ Н/кг 2 оноо

A. 120 Ж

B. 1200 Ж

C. 30 Ж

D. 300 Ж


28. 2кг масстай ачааг хэвтээ чиглэлийн дагуу 1 Н хүчээр үйлчилж 2 м газарт шилжүүлэв. Хийсэн ажлыг ол. 1 оноо

- A. 2 Ж B. 1 Ж C. 4 Ж D. 5 Ж

29. Хэлхээний хүчдэл нь 12В түүгээр гүйх гүйдэл нь 0,5А бол цахилгаан чадлыг ол. 1 оноо

- A. 6Вт B. 60Вт C. 5/12 Вт D. 0,6 В

30. Зурагт цэнэгтэй биесийн харилцан үйлчлэлцсэн байдлыг харуулжээ. 1 ба 2 дугаартай бие ямар цэнэгтэй вэ? 2 оноо



- A. 1-ээрэг, 2-ээрэг B. 1-ээрэг, 2-сөрөг C. 1-сөрөг, 2-ээрэг D. 1-сөрөг, 2-сөрөг


31. 5 атм даралт нь хэдэн Па даралттай тэнцүү вэ? 1атм=105Па 2 оноо

- A. 0,5 Па B. 50 Па C. 500 кПа D. 50 кПа

32. 90 км/ц хурдтай давхих мото спортын тамирчин минутын 1/6 хугацааны дараа зогссон бол хурдатгал нь ямар байсан бэ?

- A. -2.5 м/с² B. 1.5 м/с² C. 250 м/с² D. 25 м/с² E. 15 м/с²

33. 1 кг масстай биеийн хурдатгал хугацааны график ашиглан 8 с агшинд биеийн кинетик энерги олно уу? Биеийн анхны хурд 2 м/с




- A. 32 Ж
B. 64 Ж
C. 16 Ж
D. 6 Ж
E. 8 Ж

34. 900 кг масстай хэдэн уут цементийг 50 м өндөртэй барилгын оройд гаргахад өргөгч цамхаг ямар ажил хийх вэ? 2 оноо

- A. 450000 Ж B. 45000 Ж C. 450 Ж D. 45 Ж

35. Зурган дээр гүйдлийн дамжуулагч дахь хүчдлээс хамаарах хамаарлыг үзүүлжээ. Дамжуулагчийн эсэргүүцлийг тодорхойлно уу? 2 оноо



- A. 4 Ом
- B. 400 Ом
- C. 4 кОм
- D. 0,25 Ом

36. Хоёр төрлийн чийдэнгийн энерги хувиргалтыг зурагт үзүүлэв. Аль чийдэнг худалдаж авах нь зүйтэй талаар зөвлөгөө өгнө үү? 1 оноо



- A. 1- р чийдэн
- B. 2- р чийдэн
- C. 1 Болон 2
- E.Аль нь ч

37. Өвөл гаднаас ангидаа орж ирэхэд нүдний шил зүүсэн сурагчийн шил цантаж байдаг. Энэ нь ямар үзэгдэлтэй холбоотой вэ? 1 оноо

- A. Хайлах
- B. Уурших
- C. Царцах
- D. Конденсацлах

Задгай даалгавар

2.1 Хоорондоо 900 өнцөг үүсгэсэн 4 Н ба 3 Н хүчнүүд өгөгджээ.

a. Хүчнүүдийг зургаар дүрсэлж үзүүлнэ үү? 2 оноо

.....

b.Тэдгээрийн нийлбэр хүчийг олоорой 2 оноо

.....

2.2 $R_1=2$ ом $R_2=3$ Ом эсэргүүцэлүүдтэй биеүүдийг цуваа холбоход, түүний хүчдэл нь 40 В бол.

a. Схемийг зурна уу..... 1 оноо

b. Нийт эсэргүүцэл нь..... (...)нэгж 2 оноо

c. Гүйдлийн хүч нь (...) нэгж

2.3 Өргөгч цамхагаар хэвтээ байрласан 5 м урттай, 7800 кг/м³ нягттай, 10 см² хөндлөн огтлолтой савааг 1.2 м өндөрт өргөх ажлыг олно уу? 1 оноо

A. Савааны эзэлхүүн хэд байсан бэ? 1 оноо

.....

B. Савааны масс хэд байсан бэ? 1 оноо

.....

C. Ямар ажил хийсэн бэ? 1 оноо

.....

D. Хийгдсэн ажил ямар энергитэй тэнцүү вэ? 1 оноо

.....

...